



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№127 /341/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.07.22

Цаг үе, үйл явдал

ОЮУТАН ЦЭРГҮҮД ЭНЭ САРЫН 30-НЫ ӨДӨР ТАНГАРГАА ӨРГӨНӨ

Цар тахлын улмаас сүүлийн хоёр жил тасалдаад байсан “Оюутан цэрэг” сургалт дөрөвдүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 52 их, дээд сургуулийн 452 оюутан цэргийн эрдэмд суралцаж байна. Эдгээр оюутнууд нь энэхүү сургалтад хамрагдахын тулд голч дүн 3.4 болон түүнээс дээш байж, эрүүл мэндийн үзлэг, бие бялдрын шалгуур давсан бөгөөд эхний шатандаа “Цэргийн ерөнхий бэлтгэл” онолын сургалтыг МУИС, ШУТИС, ХУИС, МУБИС-дад тус тус танхимаар хоёр

цэргийн байр зүй, зенит, артиллерийн бэлтгэл, амьд гарах арга ухаан, анхны тусламж зэрэг 12 хичээлийг нийт 560 цагийн багтаамжтайгаар явуулж байгаа юм. Эдгээр нь цэргүүдэд бие бялдар, сэтгэл зүйн тэсвэр хатуужил олгох, байлдаанд байлдагчийн үүргийг биелүүлэх, тасаг тоотын жигдрэлтийг хангах, хүн нэг бүрт цэргийн бага мэргэжил эзэмшүүлэхэд тус сургалт чиглэж байна. Энэ хүрээнд цэргийн алба, сэтгэл зүйн бэлтгэлийг нэмэгдүүлэх үүднээс ойрын болон холын



сарын хугацаанд хамрагдсан юм. Үргэлжлүүлэн ҮБХИС-ийн Шар хад дахь Сургалтын төвд “Цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалт”-д хамрагдаж, цэргийн албанд дасгах, мэргэжлийн бэлтгэл, цэргийн мэргэжил олгох гэсэн гурван үе шаттайгаар суралцаж байна.

“Цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалт”-д хамрагдаж байгаа оюутнууд дөрвөн бүлэгт хуваагдан дадлага, сургалтад хамрагдаж байгаа юм. Сургалтыг эрчимжүүлсэн, вакумжуулсан тусгай хөтөлбөрөөр өдөрт 10 цагийн багц хичээлээр явуулж байгаа бөгөөд энэ хүрээнд цэргийн дүрэм, жагсаалын бэлтгэл, тактик, галын бэлтгэл,

зайн 5,10,20,30 километрийн маршруудыг амжилттай сайн зохион байгуулан явуулав.

Түүнчлэн оюутан цэргүүдийн дадлага сургалтын үед сэтгэл зүйн бэлтгэл, соёл хүмүүжлийн ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Тодруулбал, Цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор долоо хоног бүр, амралтын өдрийг тусгай төлөвлөгөөний хүрээнд цэргийн алба хаагчдын дунд “Тэргүүний рот, салаа шалгаруулах” уралдааныг зарлаж, долоо хоногийн эхний өдөр рот, салааны шилжин явах туг, өргөмжлөлийг гардуулан өгчээ. Энэ нь оюутан

цэргүүдийн алба хаах идэвхийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хамт олны гар нийлэмжтэй ажиллагаа, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэхэд чухал алхам болж байгаа юм. Одоогийн байдлаар тэргүүний ротоор Мотобуудлагын 1 дүгээр рот 2 удаа шалгарч, тэргүүний салаагаар Мотобуудлагын 4 дүгээр ротын I, IV салаа, Мотобуудлагын I ротын I,III салаад тэргүүлж байна.



Оюутан цэргүүдийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үүднээс сургалтын төвийн бие бүрэлдэхүүний дунд “Оюутан-цэрэг 2022” сургалтын лого буюу таних тэмдэг шалгаруулах “Дууч салаа шалгаруулах” уралдааныг зарлаж шалгаруулах шатанд явагдаж байна. Мөн найрал дуу, үндэсний бүжиг, үндэсний хөгжмийн хамтлагуудыг байгуулж урлагийн хэсэгчилсэн тоглолтыг Батлан хамгаалахын сайд болон бусад их, дээд сургуулиудын төлөөлөлд толилуулсан байна. Мэдээлэл сурталчилгааны ажлын хүрээнд цэргийн алба хаагчидтай “Эх орон” сэдвээр Үндэсний аюулгүй байдлын шинжээч, “Хурандаа нийгэмлэгийн тэргүүн”, доктор, профессор бэлтгэл хурандаа Ч.Баатар яриа хийж, өөрийн амьдралын туршлагаас хуваалцсан бол “Бэхи цолтон” ТББ-ын тэргүүн Г.Болдбаатар Монголын нууц товчооноос амьдрах ухаан, удирдах ухааныг таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2 цагийн сургалтыг зохион байгуулан, тухай сэдвийн хүрээнд асуулт хариултын тэмцээн зохион байгуулжээ.

Ийнхүү 4 сарын хугацаанд цэргийн хэргийн эрдэмд шамдаж буй оюутан залуус төлөвлөгөөт хичээл сургалтуудаа энэ сарын 30-ны өдөр дуусгаад эр цэргийн тангаргаа өргөнө.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	🌧️ 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.175.00	3.185.0
EUR 🇪🇺	3.250.0	3.270.0
CNY 🇨🇳	471.00	474.00
RUB 🇷🇺	51.50	52.80
JPY 🇯🇵	22.90	23.18
KRW 🇰🇷	2.38	2.41

ЗУРХАЙ



2022.07.22 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 24

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.16-20.41

Барилдлага:

Түлэх

ШҮТЭН БАРИЛДАГА:

САНСАР

Суудал: Гал

Энэ өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, гарагийг тахиж, хүүхэд үрчлэн авах, хур оруулах, дархны үйлд сайн. Улааны үйл, төлгө тавих, морь уралдах, хиншүү хярвас гаргахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өвчин эмгэгтэй болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 572,864,660

Эдгэрсэн

Нийт: 542,875,721

Нас барсан

Нийт: 6,398,602

Цахим шууданд

ТОРГОН ЦЭРГҮҮД АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Тулгар төрийн 2230, 2231 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815, 816 жил, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Зэвсэгт хүчин, анги, салбарынхаа хөгжил дэвшлийн төлөө залуу нас, хөдөлмөр зүтгэлээ зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа 38 ахмад дайчинд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүндэт медаль гардуулах ёслолын ажиллагааг 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн байнгын байрлалд зохион байгууллаа.

Энэ үеэр тус ангийн захирагч хурандаа М.Болдбаатар ахмад дайчдад баяр хүргэн хэлсэн үгэндээ "Өчигдөргүй өнөөдөр гэж

байдаггүйтэй адил өнөөдрийн энэ ангийн хөгжил дэвшил, нүүр царай, өнгө төрх бол цэл залуу нас, сэтгэл зүрхээ эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт зориулж халуунд нь халж, хүйтэнд нь хөрж зүтгэсэн ахмад буурлууд Та бүхний минь нөр их уйгагүй хөдөлмөр зүтгэлийн үр дүн билээ. Тиймээс залуу хойч үеийнхэндээ ахмадууд Та бүхний хийж бүтээсэн хөдөлмөр бүтээлийг сурталчлан таниулах, ахмад, дунд, залуу үеийнхний холбоо харилцааг бэхжүүлэх явдал нь бидний зайлшгүй хэрэгжүүлэх ёстой үүрэг" гэдгийг онцлолоо.

Үүний дараа ахмад дайчид залуу насаа дурсан ангийн үйл ажиллагаатай танилцсан ба тэд ажил, амьдралын дурсамжуудаа хүүрнэн нэгэн өдрийг хамтдаа өнгөрүүлэв.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА

Байлдагч Т.Өсөхбаяр: ЦЭРЭГТ ИРЭЭД ӨӨРИЙНХӨӨ МӨРӨӨДЛИЙГ ОЛСОН



түргэн ааш зангаа засаж, асуудалд уужуу ухаанаар хандах тэвчээртэй болсон. Амьдралд тун хэрэгцээтэй зарчим юм даа. Хоёрдугаарт, цаг баримталж сурсан. Цэргийн албаны үйл ажиллагаа тогтсон цагийн хуваариар явагддаг учраас тэрэнд зохицоод өөрийгөө урьдчилан бэлдээд сурчихсан гэсэн үг.

Цэргийн эрдмээс гадна бусад чиглэлээр суралцаж байна уу?

-Цэргийн бэлтгэл сургалтын хажуугаар их, дээд сургуульдаа үргэлжлүүлэн суралцах, эсвэл нийгэмд хэрэгцээтэй мэргэжил эзэмшихээс эхлээд олон боломж байна. Манай ангийн ахлагч байлдагч Б.Билгүүн цахимаар суралцаад, өнгөрсөн 6 дугаар сард дээд сургуулиа төгссөн. Бас байлдагч А.Очирсүх англи хэлнийхээ мэдлэгийг ашиглаад онжавууддаа сургалт явуулж байна. Миний хувьд ч ялгаагүй жолооны дамжаанд суралцаж байна. Удахгүй дамжаагаа төгсөнө.

Таны мөрөөдөл? -Би уг нь барилгын инженер болно гэж боддог байлаа. Нийгэмд хэрэгцээтэй байдлаас нь үүдээд. Одоо бол цэргийн хүн болохоор шийдсэн. Энэ албанд ирээд өөрийгөө офицер болбол илүү амжилттай, бас аз жаргалтай ажил минь байна гэдгийг ойлгосон. Халагдаад ҮБХИС-д элсэн суралцана гэж төлөвлөж байна.

Хошууч О.ОТГОНЦЭЦГ

Зэвсэгт хүчний 186 дугаар анги

Зэвсэгт хүчинд хугацаат цэргийн албаа нэр төртэй хааж байгаа мянга мянган түрүүч, байлдагч нарын төлөөлөл болгож Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн байлдагч Т.Өсөхбаяртай ярилцлаа.

Эрхэм байлдагч та өөрийгөө танилцуулахгүй юу?


-Намайг Төмөрбаатарын Өсөхбаяр гэдэг, Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын харьяат. Одоо 20 настай. Цэргийн албанд анх хоёр жилийн өмнө буюу 18 нас хүрээд явах хүсэлтээ өгөхөд "Та сургуулийн сурагч байна" гээд аваагүй. Дараа жил нь харин татагдаж, өдгөө Зэвсэгт хүчний 186 дугаар ангид алба хааж байна. Их сайхан анги байна.

Цэрэгт ирэхээс өмнө Т.Өсөхбаяр, ирсний дараах Т.Өсөхбаярт ямар ялгаа байгаа вэ?

-Маш их. Цэрэгт ирснээр өөрийгөө эх орны хүү шүү дээ гэдгээ мэдрэх хамгийн гоё. Саяхан "Төрийн далбааны өдөр"-өөр Эрдэнэт хотод болсон цэргийн ёслолын жагсаалд оролцсоны дараа сурагчид ирээд "Зураг авхуулья ах аа" гээд тийм нэг бахархлын харцаар харж байгаа нь маш их таалагдсан. Цэргийн алба гэдэг эгэлгүй бөгөөд хийморьлог орчин гэдгийг

бие, сэтгэлээрээ мэдрч байна. Зарим залуус цэргийн албанаас хойш сууж, явж үзээгүй мөртөө амаа эргэтэл социал сүлжээнд муулж байхыг нь харсан. Үнэхээр утгагүй санагдсан. Харуулд нэг ч өдөр хонож үзээгүй байж, энэ албыг буруутгах залуус байвал надад лав таалагдахгүй. Яагаад гэвэл бодит нөхцөл байдалд дэндүү сайхан алба. Олон ч найз нөхөдтэй боллоо, халагдаад нэгнээ санах байх аа.


Таны асуусанчлан өөрт мэдрэгдэх өөрчлөлт гэвэл харилцааны мэдрэмжтэй болсон. Энэ нь хамт олны дунд биеэ авч явах чадварт суралцаж,



ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ТОГТМОЛ ХУГАЦААНД АР ГЭРИЙНХЭНТЭЙГЭЭ ХОЛБОГДДОГ

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд хугацаат цэргийн алба хаагчдаа алба хаах хугацаанд нь ар гэр, ах дүүс, ойр дотнын хүмүүстэй утсаар тогтмол ярих боломжийг олгодог билээ. ЗХЖШ-ын даргын баталсан "Утсаар яриулах журам", ЗХЖШ-ын нэгдүгээр орлогчийн 4423 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд нэг сар тутамдаа дайчдаа ар гэрийнхэнтэй нь утсан холбоо болон дүрс бичлэгээр "уулзуулж", бүртгэлээр баталгаажуулдаг гэсэн үг юм.

Энэхүү журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийнхэн уламжлал ёсоор хугацаат цэргийн алба хаагчдаа утсаар болон дүрс бичлэгээр аав ээж, ахан дүүстэй нь холбож, уулзуулсан байна. Хугацаат албаны дайчид аав, ээждээ Үндэсний их баяр наадмын мэндийг уламжлаад, "Төрийн далбааны өдөр"-ийн цэргийн ёслолын сур жавхлантай жагсаалд оролцсон тухай, нэгтгэлийнхээ бэсрэг наадамд уран мэхийг уралдуулан, хүчийг үзэн барилдсан тухай, цэргийн албанаас сурч байгаа эрдэм мэдлэгийнхээ тухай хууч хөөрч



Таны сонорт

ҮБХИС-ИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДЭЭД СУРГУУЛЬ НЬ БАКАЛАВРЫН ДАРААХ ХӨТӨЛБӨРҮҮДЭД НЭМЭЛТ ЭЛСЭЛТ АВЧ БАЙНА

ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургууль нь бакалаврын дараах хөтөлбөрүүдэд нэмэлт элсэлт авч байна. Үүнд:

1. Авто инженерчлэл
2. Авто замын инженерчлэл
3. Электроникийн инженерчлэл
4. Кибер аюулгүй байдал
5. Менежмент
6. Нийтийн удирдлага
7. Эдийн засаг

Жич: Элсэлтийг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн элсэлтийн журмын дагуу бүртгэнэ.